

БААДАЙ БОЛОН ТҮҮНИЙ ГЭР БҮЛ

НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ
ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЯЛБАРШУУЛСАН ГАРЫН АВЛАГА



2014 он



USAID
FROM THE AMERICAN PEOPLE

Энэхүү хэвлэлд тусгасан мэдээлэл нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газарт хамаарахгүй болно.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр "Мерси кор Монгол" Олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй "Хариуцлагатай засаглалын төлөөх идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо" (APPEAL) төслийн хүрээнд хэвлэв.

Авлигатай тэмцэх газар, Мерси кор Монгол Олон улсын байгууллагын зөвшөөрөлгүйгээр хувилан олшруулахыг хориглоно.

Боловсруулсан:

Зохиогч: М.Хангал

Зураач: Б.Мөнх-Оргил, Г.Маргад

БААДАЙ БОЛОН ТҮҮНИЙ ГЭР БҮЛ


Баадай бол Монголын нэгэн томоохон их сургуулийн шилдэг оюутны нэг, нийгмийн идэвхтэй, ирээдүйтэй залуу манлайлагч. Тиймдээ ч тэр сургуулийнхаа Оюутны зөвлөлийн гишүүн, "Шударга нийгмийн төлөө" олон нийтийн байгууллагын идэвхтэн юм.

Баадай аав, ээж, өвөө, эмээгийн хамт амьдардаг. Түүний аав барилгын салбарыг удирддаг төрийн байгууллагын дарга бөгөөд олны танил нэгэн. Харин ээж нь улсын эмнэлэгт тасгийн эрхлэгч, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоодог комиссын гишүүн билээ. Баадайн ээж

саяхнаас хувийн эмнэлэг байгуулан хөл дээр нь босгох гэж хичээж байгаа ажээ.

Баадайн өвөө эх орныхоо тусгаар тогтнолын төлөө халуун амь, бүлээн цусаа хайрлалгүй тэмцэж явсан ахмад дайчин бол эмээ нь аж үйлдвэрийн паркийн анхдагч, насаараа гуталчин хийж хөдөлмөр бүтээлээ бодитоор үнэлүүлсэн буянтай буурай.

Ингээд гэр бүлийнхээ хамгийн бага нь боловч хамгийн их итгэл найдвар хүлээж ирээдүй нь болон гэрэлтэх оюутан залуу Баадайгаар төлөөлүүлэн энэ гэр бүлийн энгийн нэгэн долоо хоногийн аж байдлын зураглалыг хүргэж байна.



ДАВАА ГАРАГ БА АЛБАН ТУШААЛ



Эмээ хамгийн түрүүнд босч цай чанав. Аав, ээж, Баадай гурав удалгүй сэргээн тус тусын албандаа мордлоо. Аав, ээж хоёр нь машинаараа дөхүүлээд өгье гэсэн ч Баадай автобусаар явах нь түгжрэхгүйгээр сургуульдаа хүрэх хялбар зам гэж үзэв. Тэгээд ч түүнд автобусаар үнэгүй зорчдог виза карт бий.

Өнөөдөр Баадайн хувьд хичээл ихтэй. Оюутны зөвлөлийн гишүүний үүргийн дагуу орон нутгаас ирж суралцаж байгаа оюутнуудыг дотуур байранд оруулах, хажуугаар нь найзуудаа дотуур байранд "шахах" ажилтай.

Харин Баадайн аав шинэ хороолол барих том төслийн тендерт шалгарсан гүйцэтгэгч компанийг зарлана. Гэхдээ тэр өөрийнхөө төрсөн дүүгийн компанийг шалгаруулахаар хэдийнээ тохиролцсон билээ.

Аавынх нь энэ үйлдэл Баадайд шударга бус санагдаж автобусаар явж байхдаа аав нь албан тушаалаа хувийн ашиг сонирхолдоо ашиглаж байгаа явдлыг эргэцүүлэн бодлоо.

Ингээд өөрийн найзуудыг дотуур байранд "арын хаалга"-аар оруулах нь шударга бус явдал болохыг ойлгов. Тэр улс, эх орныхоо хөгжлийн тулгуур болсон залуу хүн би ийм төлөвшилтэй байж болохгүй гэж ухаарсан юм. Ийнхүү шударга бус явдалтай эвлэрэхгүй байхаар хатуу шийдэхэд Баадайн өмнө зурайх амьдралын зам нь улам дардан, гэрэлтэй харагдаж байлаа.

АЛБАН ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБОГДСОН ХОРИГЛОЛТ, ХЯЗГААРЛААТ:

11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, элгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1./

МЯГМАР ГАРАГ БА ГЭНЭТИЙН БЭЛЭГ

Баадайн аав энэ өдөр их л баяртай байлаа. Тэр Баадайд урьд урьдынхаас ч их халаасны мөнгө өгөв. Баадай:

-Аваа, та яасан баяртай байх юм бэ?

-Аав нь өнөөдөр шинэ жийптэй болж байгаа.

-Танд жийп байгаа шүү дээ.


-Тэрнийг ээж нь унана биз. Харин энэ бэлэгний машин хамгийн сүүлийн үеийн загвар юм чинь, өөрөө унана аа... Ийн ярилцах аав, хүү хоёрын яриг ээж нь сонирхвол, шинэ хороолол барих олон тэрбум төгрөгийн өртөгтэй том төслийн гүйцэтгэгчээр шалгаруулж өгсний хариуд дүү нь төмөр хүлэг бэлэглэхээр болсон аж.

Гэтэл үүнийг сонссон өвгөн уурлаж,

-Би та нарыг ингэж дураараа дурги гэж амь насаа хайрлалгүй тулалдаж яваагүй юм шүү. Миний үед ариун цагаан хөдөлмөрөөрөө амьдралаа босгодог байсан. Тэглээ гээд та нар муудсангүй. Хар л даа, би түмэнд хүндлэгдсэн нэртэй, төрд хайрлагдсан алдар цолтой дутагдаж гачигдах зүйлгүй сайхан л амьдарч байна гэж зэмлэхэд эмгэн:

-Энэ хэнхэг өвгөн дандаа ингэж зөрүүдэлдэг юм. Одоо цагт чинь өөрт ашигтай л байвал аргыг нь олоод юу ч хийж болдог цаг хэмээн өмөөрөв.

Аав, ээж болон хайртай өвөө, эмээгийнхээ дунд болсон энэхүү бяцхан маргаанаас Баадай амьдралын үнэнийг ойлгож байлаа. Баадай



ухаантай, шударга залуу учир амьдралаа өөд нь татах гэсэн аавыгаа ч, эх орныхоо бахархал болсон баатарлаг өвөөгөө ч, үр хүүхдээ өнгөтэй өөдтэй яваасай гэж боддог эмээгээ ч ойлгож байв. Гэхдээ тэр өвөөгийнхөө хэлсэн үгийг дахин дахин бодон ариун цагаан хөдөлмөрөөрөө амжилтад хүрэхийн сайхныг төсөөлөн байлаа.

БЭЛЭГ АВАХТАЙ ХОЛБОГДСОН ХЯЗГААРЛАЛТ:

Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1./

ЛХАГВА ГАРАГ БА ЗАДАРСАН НУУЦ



Баадайн ээж улсын эмнэлэгт тасгийн эрхлэгчийн ажил эрхэлдгийнхээ хувиар Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг албан байгууллагатай хамтарсан гэнэтийн шалгалтын багт багтав. Уг шалгалтаар зарим хувийн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцсан юм. Учир нь хувийн эмнэлгүүд эмчилгээндээ баталгаагүй эм бэлдмэл ашиглаж байна гэсэн мэдээлэл иргэдээс ирсэн байна. Бүр хуурамч онош тавьж иргэдийг залилсан тохиолдол ч гарсан аж. Шалгалт үнэхээр гэнэтийн байж чадсан тул хэд хэдэн эмнэлгээс зөрчил илрүүлж үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авав.

Уг шалгалтад Баадайн ээжийн өөрийнх нь эмнэлэг ч хамрагдсан. Баадайн ээж хуульд заасны дагуу өөрийн эмнэлгийг шалгах үүргээс татгалзав. Уг шалгалтаар ээжийнх нь эмнэлгээс зөрчил илрээгүйгээр барахгүй шалгалтад шаардагдах материалыг урьдчилан яв цав бэлтгэсэн байлаа. Баадайн ээжийн эмнэлэг шалгалтад дээд зэргээр тэнцсэн учир Эрүүл мэндийн яамнаас

сайшаалын бичиг аваад зогсохгүй төсвийн хөрөнгөөр сүүлийн үеийн тоног төхөөрөмж суурилуулах боломж ч нээгдсэн байна.

Харин Баадайн хувьд энэ өдөр хичээлээсээ эртлэн ирээд зурагт үзэж байв. Зурагтаар Авлигатай тэмцэх газрын мэдээлэл гарч байсан ба албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллээ хууль бусаар ашиглахыг хориглох тухай тайлбарлаж байлаа.

Орой ээж нь өөрийнхөө эмнэлэгт шалгалт ирэхээс өмнө шалгалтын удирдамжийг урьдчилан өгч стандартад нийцээгүй зөрчлүүдээ нууж чадсанаа гэрийнхэндээ яриу. Үүнд нь Баадай дүгнэлт хийн Авлигатай тэмцэх газраас танилцуулсан хуулийн заалтыг ээждээ тайлбарлаж хууль бус үйлдэл хийснийг нь хэллээ.

АЛБАНЫ МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХТАЙ ХОЛБОГДСОН ХОРИГЛОЛТ:

Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1./



ПҮРЭВ ГАРАГ БА СУРТАЛЧИЛГАА



Баадайн ээж шинэ эмнэлэгтээ үйлчлүүлэгч олох гэж хичээж байлаа. Эмнэлгийг хөл дээр нь босгохын тулд гэр бүлийн бүх гишүүний хүчин зүтгэл чухал юм. Олон үйлчлүүлэгчтэй болохын тулд Баадайн өвөө ахмад дайчдыг уг эмнэлгээр үйлчлүүлэхийг ятгаж үзсэн бол эмээ нь Анхдагчдын эвлэлийнхнийг уриалжээ.

Харин өнөөдөр Баадайн аав төрийн бүтээн байгуулалтын бодлого, орон сууцны үнийн асуудлаар олон нийтийн телевизэд ярилшлага өгөх ажилтай. Тэр ярилшлагынхаа далимд,

"Барилга дээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг дээд зэргээр ханган ажиллах ёстой. Бэртэж, гэмтэх аливаа аюул тулгарсан тохиолдолд нэг аятайхан эмнэлэгт хандаж болохыг зөвлөө" хэмээн ярив.

Аавыгаа зурагтаар гарч байгааг харсан Баадай баяртай байлаа. Харин шударга өвөө нь "Эхнэрийнхээ эмнэлгийг сурталчлаад л ... төрийн хүн байж ёс зүйтэй баймаар юм" гэжээ.

Баадай аавынхаа энэ үйлдлийг сайтар эргэцүүлсний эцэст хуулиар хориотой үйлдэл болохыг интернэтээс судалж мэджээ.

СУРТАЛЧИЛГААТАЙ ХОЛБОГДСОН ХЯЗГААРЛААТ:

Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1./

БААСАН ГАРАГ БА ХАНДИВЫН ХӨДӨЛМӨР



Долоо хоногийн ажлын сүүлийн өдөр. Баадайн аав туслахдаа олон арван захидал өгч харилцагч компанийн захирлуудад хүргүүлэв. Уг захидал удахгүй болох тэмдэглэлт баярыг тохиолдуулан ахмад дайчдад байр бэлэглэхэд зориулан хөрөнгө оруулалт хийхийг хүссэн байв.

Өдөр тийшээ зарим компаниас хариу ирж, нэг өрөө байр, эсвэл түүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэг үзүүлэхэд бэлэн байгаагаар уламжилсан аж.

Энэ талаар Баадайд аав нь хэлсэн бөгөөд ямар нарийн ухаанаар өвөөд нь ахмад дайчны байр олгох болсноо

сайрхан ярилаа. Тэрхүү байранд өвөө нь амьдрахгүй ч өөр хэлбэрээр ашиглаж болох аж.

Харин Баадай аавдаа хандан улс орны хөгжилд хувь нэмрээ оруулахын сайхныг сануулаад албан тушаалаа ашиглан бусдаас хандив авах нь шударга ёсонд нийцэхгүй болохыг хэлэв.

ХАНДИВ АВАХТАЙ ХОЛБОГДСОН ХЯЗГААРЛАЛТ:

Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн тусалцааг авах, хүсэхийг хориглоно.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1./

БЯМБА ГАРАГ БА ЦЭВЭР ЭРХ АШИГ

Баадайгийн гэр бүлийнхэн амралтын өдөр яаралгүйхэн босож аажуу тайван өглөөний цайгаа ууцгаав. Хоолны ширээний ард ийн яриа өрнөв.

Эмээ: - Охин минь, дүү чинь ахиад ажлаасаа гарчихаж. Одоо ажилгүй хэцүүднэ ээ. Ерөөсөө тэр хүн ажил хийж чадахгүй юм байна. Нүдний хараа муу гэдгээр нь группт оруулчихвал яасийн. Шаардлага энэ тэрийг нь хангадаг болов уу.

Ээж: - Уг нь тэгвэл зүгээр юм. Гэхдээ групп тогтоолгох шаардлагыг бараг хангахгүй л дээ. Ямар ч гэсэн дүүг материалаа бүрдүүлээд өг гэж хэл. Би комиссын гишүүдээс гуйж, шахаж байгаад бүтээхийг бодъё.

Өвөө: Та нар хялбар аргаар амьдрахыг зөв зүйл гэж бодож байна уу. Хөдөлмөр хийхгүй амьдрана гэдэг

залуу хүний хувьд гутамшиг хэмээн уурлангүй ширээнээс босож явав.

Энэхүү яриаг сонссон Баадай ээждээ дүүдээ туслах гэж байгаа нь өвөөгийн хэлснээр залуу хүнийг ажиллах хүсэл эрмэлзэлгүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй болгож байгаагаар зогсохгүй, мөн ямар ашиг сонирхлын зөрчил гаргаж байгааг тайлбарлан өгөв.

ШИЙДВЭР ГАРГАХАД НӨЛӨӨЛӨХИЙГ ХОРИГЛОХ:

12.1. Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1./



НЯМ ГАРАГ БА ОЙЛГОЛЦОЛ



Амралтын өдөр. Биеэ амрааж, тархиа сэргээх боломжит өдөр. Тиймээс салхинд гарч, зуслангийн байшиндаа гэр бүлээрээ ил зуухаа тойрон сууж хамтдаа цагийг өнгөрөөх саналыг Баадайн өвөө, эмээ гаргав.

Зуслангийн байшиндаа очоод Баадай гэрийнхэндээ "Шударга нийгмийн төлөө" ТББ-ын тэргүүнийхээ хувиар дараа долоо хоногт чухал илтгэл тавих болсноо хэллээ. Баадай илтгэлээ хэрхэн бэлтгэснээ аав ээж, өвөө эмээдээ уншиж сонирхуулав. Тэрбээр илтгэлдээ,

"...Миний эх орон баялаг түүх, баатарлаг гавьяаны алдар цуу билээ. Найман зууны тэртээ нэгэн тугийн дор нэгдэж дэлхийн тавцанд товойн

гарч ирсэн нүүдэлчдийг шударга ёс хүчирхэгжүүлсэн юм. Их эзэн Чингис хаан олон ардыг төвшитгэхдөө дайсан байлаа ч шударга аваас нөхөр болгон төрийн их хэргийг атгуулж байв. Тиймээ, монголчууд бид шударга ёсны үр сад.

Шударга ёсыг эрхэмлэх чанарыг бидэнд эцэг өвгөд минь өвлүүлсэн болохоор монгол хүн бүр шударга ёсыг, шударга нийгмийг цогцлоохыг хүснэ.

Шударга нийгэм гэж иргэд нь ухамсартай, мэдлэгтэй, хүнлэг энэрэнгүй байж чаддаг, хууль дүрэм нь хүн бүрт адил тэгш, алагчлалгүй үйлчилдэг нийгмийг хэлнэ гэж би боддог. Манай орон ардчиллын замаар хурдацтай хөгжиж дэлхий дахинтай

хөл нийлүүлэн алхаж байгаа ч хөгжил дэвшлийг дагасан нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч байна.

Тэдгээрийн нэг нь авлига, ашиг сонирхлын зөрчил юм. Энэ сөрөг үзэгдэлтэй зөвхөн нэг байгууллага ганцаараа тэмцээд үндсээр нь устгахад хүндрэлтэй билээ.

Иймд өрх айл бүр, иргэн бүр авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг тууштай зогсож, шударга нийгмийн төлөө хамтдаа тэмцсэнээр үр дүнд хүрэх юм...» хэмээлээ.

Баадай үргэлжлүүлэн хүн болгон хариуцсан үүрэгт ажлаа хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавьж, хариуцлагатай ажиллавал шударга нийгэм цогцлох учиртай гэж бодлогоо ч хэллээ.

Ингээд Баадай энэ долоо хоногт аавынхаа шинэ хороолол барих том төслийн тендерт төрсөн дүүгийнхээ компанийг шалгаруулж шанд нь жийп машин авсан, ээжийнхээ хууль бус аргаар үйлчлүүлэгч олсон зэрэг үйлдлүүдийг шүүмжлэн албан үүргээ хувийн эрх ашгийн үүднээс ашигладаг байдлаа зогсоохыг гуйв. Энэ нь

хуулиар хориглосон үйлдэл болохыг мөн цаашдаа асар их хор уршигтай талаар тайлбарлан өгөв.

Хүүгээ ийнхүү үеийнхэндээ илтгэл тавьж, шударга нийгмийг бүтээхэд үлгэр дуурайл үзүүлж байгаад аав, ээж, өвөө, эмээ нь ихэд баяртай байв.

Хүүгийнхээ яриаг анхааралтай сонссон өвөө нь Баадайд “Миний хүү зөв хүн болж төлөвшиж байгаа юм байна. Ийм хойч үе өсч байгаа юм чинь манай улс лавтай хөгжинө. Ер нь энэ авлига чинь улс нийтээрээ урагшлах хөгжлөөс хулгайлж амин хувиа хичээж байгаа увайгүй хэрэг байгаа юм шүү. Миний хүү үе тэнгийнхээ хүүхдүүдийг манлайлан шударга сайн хүн болж хүмүүжиж байгаад өвөө нь бахархаж байна.” гэж хэллээ.

Чингээд аав, ээж, эмээ, өвөө нь Баадай хүүгийнхээ шударга нийгмийг бүтээх зорилгод нь чадах бүхнээрээ туслахаар зогсохгүй цаашид хариуцсан ажил үүргээ үнэнч шударгаар биелүүлэн хууль бус үйдэлтэй шийдэмгий тэмцэж, эрүүл ирээдүйг бүтээлцэнэ гэдгээ батлан хэллээ.

Бидэнтэй нэгдээрэй



Шударга НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА



<https://www.facebook.com/pages/xamtdaa.mn/>



<https://twitter.com/@nocorruptionMGL>



www.xamtdaa.mn

Авлига, ашиг сонирхлын зөрчлийн
талаарх гомдол мэдээллийг Авлигатай
тэмцэх газрын 1800-1969 дугаарт өгнө үү.

Цахим хуудас: www.iaac.mn